

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 10 сарын 03 өдөр

Дугаар А/31

Арвайхээр сум

Шинэ болон дахин сэргэж буй халдварын сэжигтэй тохиолдолд ажиллах шуурхай хариу арга хэмжээний баг томилох тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 7 дугаар сарын 19-ны өдрийн “Коронавируст халдвар (ковид-19), Томуу, томуу тест өвчний эсрэг хариу арга хэмжээг эрчимжүүлэх тухай 07 дугаар албан даалгавар, 2022 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн “Журам, заавар батлах тухай” 373 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Шинэ болон дахин сэргэж буй халдварын сэжигтэй тохиолдолд ажиллах шуурхай хариу арга хэмжээний багийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, гишүүдийн ажиллах чиг үүргийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Шуурхай хариу арга хэмжээний багийн гишүүдийг сургаж, бэлэн байдлыг хангуулахыг Эрүүл мэндийн газрын нийгмийн эрүүл мэндийн хэлтэс (М.Золзаяа), Бүсийн оношилгоо эмчилгээний төв (Э.Хүдэрчулуун), Зоонозын өвчин судлалын төв (Б.Сүхбаатар) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Шуурхай хариу арга хэмжээний багт ажиллах эмч, мэргэжилтнүүдийг хамгаалах хувцас хэрэгсэл, хоол хүнс, эм, эмнэлгийн хэрэгслээр хангаж, халдварын голомтонд ажиллахад шаардалагатай зардлыг тооцон зарцуулахыг Эрүүл мэндийн газрын санхүүч (Б.Валя)-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Хяналт шинжилгээ, мэдээллийн хэлтэс (Я.Жаргал)-д үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны 11 дугаар сарын 13-ны өдрийн “Коронавируст халдвар (Ковид-19)-ын сэжигтэй тохиолдолд ажиллах шуурхай хариу арга хэмжээний баг” томилох тухай А/40 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА




Д.ШИВААННҮРДЭВ

My Doc.tushaal/EMG/

189000127


Эрүүл мэндийн газрын даргын
2022 оны 10 сарын 03 ны өдрийн
А/31 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ШИНЭ БОЛОН ДАХИН СЭРГЭЖ БУЙ ХАЛДВАРЫН СЭЖИГТЭЙ
ТОХИОЛДОЛД АЖИЛЛАХ ШУУРХАЙ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ
БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

№	Нэгдүгээр багийн бүрэлдэхүүн			
	Ажил, мэргэжил	Овог нэр	Ажлын газар, албан тушаал	Холбоо барих утасны дугаар
1	Тархвар судлагч эмч /ажлын хэсгийн ахлагч/	Э.Лхагвадулам	ЭМГ-ын НЭМХ-ийн мэргэжилтэн	89052036
2	Халдвартын их эмч	Ч. Эрдэнэтуяа	БОЭТ-ийн халдвартын их эмч	99018570
3	Сувилагч	Ц.Үржинчимэг	БОЭТ-ийн халдвартын тасгийн сувилагч	99327561
4	Лаборант	Х.Мөнхцэцэг	БОЭТ-ийн нэгдсэн лабораторийн лаборант	96131199
5	Ариутгагч	Д.Цэндхорол	ЗӨСТ-ийн ариутгагч	88094498
6	Жолооч	М.Төмөртоогоо	БОЭТ-ийн жолооч	99329812
Хоёрдугаар багийн бүрэлдэхүүн				
1	Тархвар судлагч эмч /ажлын хэсгийн ахлагч/	Ц.Эрхномуун	ЭМГ-ын НЭМХ-ийн мэргэжилтэн	88086231
2	Халдвартын их эмч	Ж.Дэмиддолгор	БОЭТ-ийн халдвартын их эмч	88039089
3	Сувилагч	Р.Оюунтүлхүүр	БОЭТ-ийн халдвартын тасгийн сувилагч	99327033
4	Лаборант	Б.Лхагвадорж	БОЭТ-ийн нэгдсэн лабораторийн лаборант	95181822
5	Ариутгагч	А.Өлзиймаа	ЗӨСТ-ийн ариутгагч	88757789
6	Жолооч	О.Гантөр	БОЭТ-ийн жолооч	89665805

Эрүүл мэндийн газрын даргын
2022 оны 10 сарын 03 ны өдрийн
А/Б/ дугаар тушаалын хоёрдугаар
хавсралт



ГИШҮҮДИЙН АЖИЛЛАХ ЧИГ ҮҮРЭГ

Нэг. Шуурхай хариу арга хэмжээний багийн ахлагч, тархвар судлаач эмчийн үүрэг:

1. Багийн зохион байгуулалтаар ханган, голомтонд ажиллахад шаардлагатай хамгаалах хувцас, хэрэгсэл, эм, эмнэлгийн хэрэгслийн бэлэн байдлыг хангуулах
2. Орон нутгийн болон эрүүл мэндийн байгууллагуудын удирдлагууд, холбогдох байгууллагуудыг цаг үеийн нөхцөл байдлын талаарх мэдээллээр тогтмол хангах
3. Сэжигтэй тохиолдолд тархвар зүйн судалгаа хийж, өвчний эх уурхай, дамжих зам, нөлөөлж буй хүчин зүйлийг тодорхойлж, хариу арга хэмжээг оновчтой шуурхай зохион байгуулах
4. Голомтонд хариу арга хэмжээг зохион байгуулан, тулгамдаж буй асуудал, цаашид шийдвэрлэх арга замыг аймаг, сумын онцгой комиссын хуралд санал оруулж шийдвэрлүүлэх
5. Сэжигтэй болон батлагдсан тохиолдолд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх замын зураглал гаргаж, үйлчлүүлэгчдийн урсгал хөдөлгөөнд зохицуулалт хийх, халдвараас сэргийлэх, халдвар хяналтын дэглэмийг баримтлах
6. Халдварын сэргийлэлт, хяналтын багийн үйл ажиллагааг эрчимжүүлэх
7. Багийн бүрэлдэхүүнийг шинэ болон сэргэж буй халдварын болзошгүй аюулаас сэргийлэхийн тулд халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлж, хяналт тавих
8. Халдварын тархалтын байдлыг багийн гишүүд болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, үүрэг даалгавар зөвлөгөө өгч, биелэлтэнд хяналт тавих
9. Голомтонд ажилласан тайланг нэгтгэж, холбогдох байгууллагуудад тухай бүр өгөх

Хоёр. Халдварын их эмч:

1. Өвчтөний биеийн байдлыг үнэлж, онош тодруулах ажлыг зохион байгуулан, эмчилгээнд цаг алдалгүй хамруулах
2. Өвчтөний биеийн байдалд тогтмол хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд нарийн мэргэжлийн зөвлөх эмч нараас зөвлөгөө авах
3. Өвчтөний эмчилгээнд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийг тооцон, багийн ахлагч болон тухайн байгууллагын удирдлагад танилцуулж, шийдвэрлүүлэх
4. Өвчний түүхийг үнэн зөв, бүрэн хөтлөх
5. Өвчтөний хавьтлуудыг үзлэг, шинжилгээнд хамруулж, хяналтанд авах
6. Өвчтөний биеийн байдлын талаарх мэдээллийг холбогдох удирдлагуудад тухай бүр мэдээлэх
7. Өвчтөнд тусламж үйлчилгээ үзүүлэхдээ халдвараас сэргийлэх дэглэмийг чанд баримтлан ажиллах
8. Голомтонд ажилласан тайланг багийн ахлагчид хүлээлгэн өгөх

Гурав. Сувилагчын үүрэг:

1. Эмчийн зааврын дагуу өвчтөнд сувилахуйн тусламж үйлчилгээг чанартай, шуурхай үзүүлэх
2. Өвчтөний биеийн байдлыг тогтмол үнэлж, эмчлэгч эмчид мэдээлэх
3. Өвчтөнд асаргаа сувилгааг тушаал шийдвэрийн дагуу үзүүлж, үйлчлүүлэгчийн биеийн байдлыг үнэлэх хуудсыг үнэн зөв хөтлөх
4. Холбогдох анхан шатны бичиг баримтыг тухай бүр үнэн зөв хөтлөх
5. Өвчтөнд тусламж үйлчилгээ үзүүлэхдээ халдвараас сэргийлэх дэглэмийг чанд баримтлан ажиллах
6. Голомтонд ажилласан тайланг багийн ахлагчид хүлээлгэн өгөх

Дөрөв. Лаборантын үүрэг:

1. Эмчийн зааврын дагуу өвчтөнөөс шаардлагатай шинжилгээг авч, холбогдох журмын дагуу дагалдах хуудсын хамт зөөвөрлөх
2. Өвчтөний хавьтлуудаас шаардлагатай шинжилгээг авч, холбогдох журмын дагуу дагалдах хуудсын хамт зөөвөрлөх
3. Шаардлалтай тохиолдолд шинжилгээг шуурхай хийж, хариуг эмчлэгч эмчид өгөх
4. Холбогдох анхан шатны бичиг баримтыг тухай бүр үнэн зөв хөтлөх
5. Өвчтөнд тусламж үйлчилгээ үзүүлэхдээ халдвараас сэргийлэх дэглэмийг чанд баримтлан ажиллах
6. Голомтонд ажилласан тайланг багийн ахлагчид хүлээлгэн өгөх

Тав. Ариутгагчийн үүрэг:

1. Голомтын эцсийн халдваргүйтгэлд шаардлагатай тоног төхөөрөмж, ариутгал халваргүйтгэлийн бодисын бэлэн байдлыг хангах
2. Халдварын голомтонд байнгын болон эцсийн халдваргүйтгэлийг тархвар судлагч эмчийн хяналтан дор заавар журмын дагуу 24 цагийн дотор хийх
3. Холбогдох анхан шатны бичиг баримтыг тухай бүр үнэн зөв хөтлөх
4. Ариутгал халдаргүйтгэл хийх явцад халдвараас сэргийлэх дэглэмийг чанд баримтлан ажиллах
5. Голомтонд ажилласан тайланг багийн ахлагчид хүлээлгэн өгөх

Зургаа. Жолоочийн үүрэг:

1. Машиныг сааталгүй үйлчлэх техникийн бэлэн байдлыг хангах
2. Дуудлага хүлээн авмагц нэг цагийн дотор багийн гишүүдийг цуглуулах
3. Дуудлагын багийн ахлагчийн шууд удирдлаганд ажиллаж явсан километрийн тооцоог гаргах
4. Машиндаа байнгын ба эцсийн халдваргүйтгэлийг хийлгэх